



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв аймгийн Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ТӨА-2025/097/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Саранчимэг Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмол сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.08.25 № 01/155
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Х.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 2022 оны 05 дугаар тогтоолын дагуу олгогдож буй, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний 2024 оны нэг иргэнд ногдох нормативт зардлын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас олгоогүйн улмаас 120,942.0 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн төсвийн байгууллагуудын дулааны төлбөр тооцохдоо хангагч байгууллага, хэрэглэгч байгууллага нарын хамтарсан ажлын хэсэг гарч тухайн барилгын эзлэхүүнийг хэмжиж Дулааны эрчим хүч нийлүүлэх гэрээ байгуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 2018 оны 292 дугаар тогтоолын дагуу тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг ерөөний урт, өргөн, өндөр/давхрын бодит өндөр/-ийн хэмжээгээр тооцоогүй байна.

Бусад асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэн

112596477

ажиллахаар баталснаас хэрэгжилт 97,5 хувьтай гэж тайлагнасан байна.
байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,116,127.61	275,434,338.26
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	52,024,265.22	12,983,216.66
312	Банканд байгаа бэлэн мөнгө	52,024,265.22	12,983,216.66
3121	Төгрөг	52,024,265.22	12,983,216.66
31211	Төрийн сангийн харилцах	52,024,265.22	12,983,216.66
31213	Арилжааны банкин дахь харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	8,046,664.00	121,457,424.62
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	276,659.15
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	8,046,664.00	120,941,965.47
335	Бусад авлага	(0.00)	238,800.00
3351	Байгууллагаас авах авлага	-	238,800.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	(0.00)	(0.00)
34	УРЬДЧИЛГАА	-	0.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	0.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	113,045,198.39	140,993,696.98
351	Түүхий эд материал	68,841,429.83	77,434,095.42
35110	Тусгай зориулалттай материал	37,476,856.17	54,075,230.66
35130	Эм боох материал	31,364,573.66	23,358,864.76
354	Хангамжийн материал	44,203,768.56	63,559,601.56
35410	Бичиг хэргийн материал	418,900.00	639,900.00
35420	Аж ахуйн материал	40,570,351.43	60,507,261.43
35440	Түлш шатах тослох материал	0.13	0.13
35460	Хүнсний материал	2,883,780.00	2,412,440.00
35470	Бусад хангамжийн материал	330,737.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	539,840,076.11	604,024,628.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	539,840,076.11	604,024,628.93
392	Биет хөрөнгө	509,814,076.11	573,723,295.60
39201	Барилга, байгууламж	344,714,488.13	344,714,488.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(45,710,915.08)	(61,183,397.08)
39203	Авто тээврийн хэрэгсэл	115,054,800.00	54,230,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(97,168,341.71)	(42,476,041.75)
39205	Машин, тоног төхөөрөмж	178,179,248.45	280,761,989.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(71,292,194.83)	(93,751,165.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,332,279.60	51,482,279.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,334,444.25)	(22,697,088.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,000,000.00	65,923,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(920,524.20)	(5,341,048.44)
39217	Номын фонд	959,680.00	2,059,680.00
393	Биет бус хөрөнгө	30,026,000.00	30,301,333.33
39301	Програм хангамж	400,000.00	280,000.00
39302	Хасагдуулга	(400,000.00)	(4,666.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,026,000.00	30,026,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	712,956,203.72	879,458,967.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	291,100.00	291,114.02
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	291,100.00	291,114.02
413	Өглөг	291,100.00	291,114.02

Төв аймгийн Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	14.02
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	0.00
4136	Бусад өглөг	291,100.00	291,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	0.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	291,100.00	291,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	712,665,103.72	879,167,853.17
51	Засгийн газрын хувь оролцоо	712,665,103.72	879,167,853.17
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	195,310,308.92	195,310,308.92
51101	Өмч: -Төрийн өмч	195,310,308.92	195,310,308.92
512	Хуримтлагдсан үр дүн	492,947,152.39	677,249,901.84
51210	Өмнөх үеийн үр дүн	492,947,152.39	510,747,152.39
51220	Тайлант үеийн үр дүн	-	166,502,749.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,407,642.41	6,607,642.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	712,956,203.72	879,458,967.19

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	753,567,388.86	990,739,156.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193,182,637.60	160,486,098.71
120	Нийтлэг татварын бус орлого	193,182,637.60	160,486,098.71
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	171,087,868.00	126,111,941.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	21,094,769.60	32,374,157.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	560,384,751.26	830,253,057.61
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,074,000.00	36,285,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,074,000.00	36,285,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	534,310,751.26	793,967,457.61
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас	534,310,751.26	793,967,457.61
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	587,717,715.58	824,236,406.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	587,717,715.58	824,236,406.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,717,677.44	820,595,222.29
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	360,023,868.07	517,759,988.59
210101	Цалин	241,990,566.04	259,603,133.91
210102	Нэмэгдэл цалин	82,217,933.90	253,608,854.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,720,000.00	4,548,000.00
210104	Урамшуулал	32,095,368.13	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,437,797.29	68,723,899.98
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,974,340.82	46,121,929.54
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,570,458.43	5,327,009.66
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,187,024.48	3,909,545.99
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	698,430.13	2,604,104.81
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,007,543.43	10,761,309.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,269,132.86	26,306,655.42
210301	Гэрэл цахилгааны зардал	6,562,792.86	6,272,740.42
210302	Түлш, халаалтын зардал	15,424,190.00	20,033,915.00
210303	Цэвэр, бохир усны зардал	282,150.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	17,932,471.00	18,614,905.60
210401	Бичиг хэргийн материал	2,564,600.00	2,041,800.00
210402	Тээвэр, шатахууны зардал	14,047,871.00	14,673,650.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	970,000.00	985,000.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	350,000.00	552,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	-	362,455.60
2105	Нормативт зардал	55,684,318.62	69,234,186.82
210501	Эм	39,552,568.62	49,268,516.82
210502	Хоол	16,131,750.00	19,965,670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	417,200.00	3,388,000.00
210601	Багаж хэрэгсэл	12,200.00	-
210604	Урсгал засвар	405,000.00	3,388,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,408,000.00	2,758,000.00
210702	Дотоод томилолтын зардал	1,408,000.00	2,758,000.00

Төв аймгийн Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	771,500.00	1,025,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	8,800.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	350,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	82,000.00	86,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,400.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	120,100.00	120,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,773,389.60	112,783,685.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,545,746.00	37,306,297.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,227,643.60	75,477,388.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38.14	3,641,184.58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38.14	3,641,184.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38.14	3,641,184.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	165,849,673.28	166,502,749.45
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	165,849,673.28	166,502,749.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	553,666,599.59	719,357,756.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,328,512.33	10,046,664.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,328,512.33	10,046,664.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,328,512.33	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,328,512.33	2,000,000.00
120009	Бусад орлого	-	8,046,664.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	552,338,087.26	709,311,092.14
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,074,000.00	36,285,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,074,000.00	36,285,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	526,264,087.26	673,025,492.14
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	526,264,087.26	673,025,492.14
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	527,440,891.36	744,848,804.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,440,891.36	744,848,804.70
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	527,440,853.22	741,207,620.12
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	360,023,868.07	515,792,233.70
210101	Үндсэн цалин	241,990,566.04	322,062,614.32
210102	Нэмэгдэл	82,217,933.90	160,880,801.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,720,000.00	6,484,300.00
210104	Үр дүнгийн урамшуулал	32,095,368.13	26,364,517.87
2102	Ажил ологчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,437,797.29	71,207,100.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,974,340.82	46,591,200.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,570,458.43	5,481,300.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,187,024.48	5,431,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	698,430.13	2,740,700.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,007,543.43	10,962,600.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	24,873,961.86	26,306,655.42
210301	Гэрэл цахилгааны зардал	7,989,592.86	6,272,740.42
210302	Түлш, халаалтын зардал	16,602,219.00	20,033,915.00
210303	Цэвэр, бохир усны зардал	282,150.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,814,971.00	23,828,650.00
210401	Бичиг хэрэг	2,164,100.00	2,700,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,047,871.00	14,673,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,305,000.00	1,405,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,298,000.00	5,049,500.00
2105	Нормативт зардал	53,756,600.00	61,291,999.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,275,400.00	38,335,669.00
210502	Хоол, хүнс	15,739,200.00	19,429,330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	742,000.00	3,527,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,780,700.00	28,646,840.00
210601	Багаж техник хэрэгсэл	1,400,000.00	9,018,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,032,200.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	6,348,500.00	16,628,840.00
2107	Томилолт, зочны зардал	1,408,000.00	2,758,000.00
210702	Дотоод албан томилолт	1,408,000.00	2,758,000.00

Төв аймгийн Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	771,500.00	1,017,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	82,000.00	86,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,400.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	120,100.00	120,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,573,455.00	10,359,042.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,573,455.00	10,359,042.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38.14	3,641,184.58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38.14	3,641,184.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38.14	3,641,184.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	26,225,708.23	(25,491,048.56)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,482,106.00	13,550,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,482,106.00	13,550,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,482,106.00	13,550,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,482,106.00	13,550,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(18,482,106.00)	(13,550,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	7,743,602.23	(39,041,048.56)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,280,662.99	52,024,265.22
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52,024,265.22	12,983,216.66

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,721,266.90	305,792,225.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,721,266.90	305,792,225.23
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	126,088,215.11	126,088,215.11
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	195,310,308.92	24,407,642.41	492,947,152.39	712,665,103.72
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	195,310,308.92	24,407,642.41	492,947,152.39	712,665,103.72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	17,800,000.00	17,800,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	195,310,308.92	24,407,642.41	510,747,152.39	730,465,103.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(17,800,000.00)	-	(17,800,000.00)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	166,502,749.45	166,502,749.45
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	195,310,308.92	6,607,642.41	677,249,901.84	879,167,853.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	52,024,265.22	(52,024,265.22)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	792,496,700.00	722,113,204.70	70,383,495.30	91.1
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	792,496,700.00	722,113,204.70	70,383,495.30	91.1
Бараа, үйлчилгээний зардал	792,496,700.00	722,113,204.70	70,383,495.30	91.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,132,100.00	515,792,233.70	35,339,866.30	93.6
Үндсэн цалин	378,032,000.00	322,062,614.32	55,969,385.68	85.2
Нэмэгдэл	131,245,100.00	160,880,801.51	(29,635,701.51)	122.6
Унаа, болон бусад нөхөн олговор	9,855,000.00	6,484,300.00	3,370,700.00	65.8
Урамшуулал	32,000,000.00	26,364,517.87	5,635,482.13	82.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,257,100.00	71,207,100.00	50,000.00	99.9
Тэтгэврийн даатгал	46,591,200.00	46,591,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	5,481,300.00	5,481,300.00	-	100.0
ҮОМШӨ ний даатгал	5,481,300.00	5,431,300.00	50,000.00	99.1
Ажилгүйдлийн даатгал	2,740,700.00	2,740,700.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	10,962,600.00	10,962,600.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	49,507,200.00	23,828,650.00	25,678,550.00	48.1
Бичиг хэрэг	2,092,800.00	2,700,500.00	(607,700.00)	129.0
Тээвэр (шатахуун)	38,834,600.00	14,673,650.00	24,160,950.00	37.8
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,150,800.00	1,405,000.00	1,745,800.00	44.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,429,000.00	5,049,500.00	379,500.00	93.0
Нормативт зардал	64,886,800.00	61,291,999.00	3,594,801.00	94.5
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,943,400.00	38,335,669.00	6,607,731.00	85.3
Хоол, хүнс	15,216,400.00	19,429,330.00	(4,212,930.00)	127.7
Нормын хувцас зөөлөн эдлэл	4,727,000.00	3,527,000.00	1,200,000.00	74.6
Эд хогшил худалдан авах	31,000,000.00	24,259,080.00	6,740,920.00	78.3
Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	10,968,000.00	2,032,000.00	84.4
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Урсгал засвар	15,000,000.00	10,291,080.00	4,708,920.00	68.6
Томилот, зочны зардал	2,616,900.00	2,758,000.00	(141,100.00)	105.4
Дотоод албан томилот	2,616,900.00	2,758,000.00	(141,100.00)	105.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,017,100.00	1,017,100.00	-	100.0
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	576,000.00	576,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	86,000.00	86,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	180,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-	100.0
Газрын төлбөр	120,100.00	120,100.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	21,079,500.00	21,959,042.00	(879,542.00)	104.2
Бараа үйлчилгээний бусад зардал	21,079,500.00	21,959,042.00	(879,542.00)	104.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	792,496,700.00	675,025,492.14	117,471,207.86	85.2
НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	792,496,700.00	673,025,492.14	119,471,207.86	84.9
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	792,496,700.00	673,025,492.14	119,471,207.86	84.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,000,000.00	(2,000,000.00)	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,000,000.00	(2,000,000.00)	-

Төв аймгийн Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	52,024,265.22	(52,024,265.22)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,983,216.66	(12,983,216.66)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	20	20	-	-
Удирдах ажилтан	1	1	-	-
Гүйцэтгэх ажилтан	13	13	-	-
Үйлчлэх ажилтан	6	6	-	-

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

3.1 Аудитаар нийт 7,088.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7,088.9 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7 нэр төрлийн нийт 34,687.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй байна.	1	-			1	-		-	1	-	1	-
Тайлант онд 3 ажилтны цалин хөлсийг нийгмийн даатгалын цахим системд 2,700.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	2,700.0			1	2,700.0	1	2,700.0				
Тайлант оны эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,528.5 мянган төгрөгөөр Санхүүгийн үр дүнгийн тайлангаар илүү тайлагнасан байна.	1	2,528.5			1	2,528.5	1	2,528.5				
Тайлант оны цалин хөлсний зардлыг Санхүүгийн үр дүнгийн тайланд 1,860.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	1,860.4			1	1,860.4	1	1,860.4				
Дүн	4	7,088.9	-	-	4	7,088.9	3	7,088.9	1	-	1	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 272.0 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 272.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 20 иргэн байгууллагын 30,971.4 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	-					1	-				
Төлбөрийн цахим баримтын цахим системийн нэхэмжлэх дээр 12 байгууллагын 13,536.6 мянган төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.	1	-					1	-				
Эрүүл мэнд даатгалын ерөнхий газартай сар бүр тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан боловч ЭМДЕГ-аас 7-12 саруудын санхүүжилтийг олгоогүйн улмаас төлбөртэй үйлчилгээний авлага 52,167.7 мянган төгрөгт хүрч оны эхнээс 44,120.8 мянган төгрөгөөр буюу 6.4 дахин өссөн байна.	1	-					1	-				
Шалгагдагч байгууллагын нэхэмжилсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний баримтыг ЭМДЕГ-аас шалган баталгаажуулж, нийт 20,027.8 мянган төгрөгийн зөрчилтэй үйлчилгээний төлбөрийг хасаж санхүүжүүлсэн байна.	1	-					1	-				
Тайлант онд 14 ажилтанд 272.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг илүү эдлүүлсэн.	1	272.0	1	272.0								
Дүн	5	272.0	1	272.0	0	0	4	0	0	0	0	0

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1		-		1	
Дүн	1		-		1	